

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:
МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ
МЭДЭЭЛЭЛ**

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын Авлигын эсрэг хууль, УИХ-ын 2005 оны 25, 2007 оны 3, 9, 72, 2008 оны 13 дугаар тогтоолын хэрэгжилт болон авлигын ерөнхий нөхцөл байдлыг мэдээлж байна.

Нэг. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хамтарсан ажлын хэсгийг байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллав.

Хамтарсан ажлын хэсэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг яам, агентлагуудад шалгаж, нэгдсэн дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаас “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээний болон эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд хэвшүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үр дүнг нэгтгэн тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгосон. Энэ ажлыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтарсан ажлын хэсэг “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт” болон “НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх нь” сэдэвт сургалт, семинарыг яамны дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарыг хамруулан зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, үр дүн, төлөвлөгөөг сайжруулах арга замын талаар хэлэлцэв. 2008 онд 26 байгууллага төлөвлөгөөтэй ажиллаж байсан бол дээрх сургалт, семинарын үр дүнд 55 байгууллага “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 4 тулгуурт зарчимд үндэслэн боловсруулан хэрэгжүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, арга зүйн удирдлагаар ханган ажиллав. Дээрх төлөвлөлтийг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны олон улсын стандартад нийцүүлэн бүх яам, агентлагийн түвшинд зохион байгуулсан нь ажлын үр дүнг бодитой үнэлж, дүгнэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.

Аймаг, орон нутагт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх боломж, нөхцөлөөр хангах зорилгоор аймгуудын түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний загварыг боловсруулж, Хэнтий, Төв, Дундговь аймагт арга зүйн туслалцаа үзүүлж ажилласны үр дүнд Хэнтий, Дундговь аймаг “Шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах талаар бүсчилсэн сургалтыг Дархан-Уул, Дундговь аймагт 11 аймгийн төр, захиргааны байгууллагын төлөөллийг хамруулан зохион байгуулав.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн албатай нягт хамтран ажилласны үр дүнд НҮБ-ын олон улсын шинжээчдийн багтай хамтран “НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын өөрийн үнэлгээний тайлан”-г боловсруулан НҮБ-д хүргүүлсэн нь цаашид Монгол Улсын хэмжээнд авлигатай тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах болон техникийн туслалцаа авах чиглэлийг тогтоосон бодит үр дүнтэй ажил болсон.

Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, арга зүйн удирдлагаар ханган, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг яам, агентлаг, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудаас хүлээн авч, хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх бэлтгэлийг хангаад байна.

Авлигатай тэмцэх газар тодорхой чиг үүргийн хэлтэс, албаны төлөөллөөс бүрдсэн ажлын 3 баг томилон бүх аймагт 2 удаа ажиллуулж, Авлигын эсрэг хууль, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж үнэлэх ажлыг зохион байгууллаа. Ажлын баг төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлт, Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй танилцаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа 2010 онд дуусч байгаатай холбогдуулан Авлигатай тэмцэх дунд хугацааны Үндэсний стратегийн төслийг олон улсын байгууллага, зөвлөхтэй хамтран боловсруулж байгаа ба төслийг

энэ онд багтаан холбогдох байгууллагуудад танилцуулан санал авч, Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байна.

Авлигатай тэмцэх газар нь Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 143 дугаар тогтоолыг сурталчлах, тогтоолын заалтыг нэг мөр ойлгож мөрдөх, төрийн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийг тайлбарлан таниулах, үнэлэх аргачлалын талаар 58 байгууллагын ажилтнуудад сургалт, семинар зохион байгуулж, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны, Ашигт малтмалын газрын, Гаалийн ерөнхий газрын, Иргэний нисэхийн ерөнхий газрын, Мэдээлэл, шуудан харилцаа холбооны технологийн газрын, Нийгмийн даатгалын ерөнхий газрын, Эрчим хүчний газрын, Эрүүл мэндийн газрын, Улсын мөрдөн байцаах газрын албан хаагчдын ёс зүйн дүрмийн төслийг тус тус хянан үзэж, санал өгсөний дагуу дээрх байгууллагууд ёс зүйн дүрмээ батлан мөрдөж байна.

Авлигатай тэмцэх газар авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гадаад орны авлигатай тэмцэх байгууллагын туршлагыг судлан ашиглахад анхаарч, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэн БНХАУ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний төв товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн комисс, Малайз Улсын Авлигын эсрэг комисстой харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурахаар харилцан тохиролцсон.

Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, санал, санаачлагыг нь дэмжин туслах, авлигатай тэмцэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.

Авлига, хүнд сурталтай тэмцэх, авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах чиглэлээр төрийн бус байгууллагын сүлжээг үүсгэн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Одоо бүх аймагт ийм сүлжээ үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж байна. Авлигатай тэмцэх газраас тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, арга зүйн туслалцаа үзүүлэн үйл ажиллагааны нь төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна .

Авлигатай тэмцэх газрын дарга, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Иргэний нийгмийн зөвлөлийн ерөнхий зохицуулагч нарын баталсан аймгийн Засаг дарга, орон нутаг дахь төрийн бус байгууллагуудын сүлжээний ахлагч, Авлигатай тэмцэх газрын хооронд 2008 онд байгуулсан гурвалсан гэрээний

хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг дарга нарт болон орон нутаг дахь Төрийн бус байгууллагын сүлжээний ахлагч нарт зөвлөмж хүргүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах, шалган туслах, үнэлэлт өгөх ажлыг 21 аймагт зохион байгууллаа.

Орон нутаг дахь Төрийн бус байгууллагын сүлжээний ахлагч нарт авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар мэдлэг олгох сургалтыг 2009 онд Улаанбаатар хотноо 2 удаа зохион байгуулж, шаардлагатай гарын авлага, сурталчилгааны материалаар хангав.

2009 онд 21 аймгийн төрийн бус байгууллагын сүлжээний 105 төлөөлөгчдийг хамруулсан бүсчилсэн сургалтыг Орхон, Өмнөговь, Ховд аймагт зохион байгуулж, Төрийн бус байгууллагын сүлжээний үйл ажиллагаатай танилцах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох зэрэг ажлыг зохион байгуулж, Засаг даргатай байгуулсан гурвалсан гэрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллав.

Бизнесийн харилцаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, ялангуяа эрх бүхий байгууллагаас баталсан норматив-техникийн баримт бичиг болох стандартыг мөрдөх явцад гарч буй саадыг хэрхэн даван туулах, түүнийг өөрчлөх, шинэчлэх, боловсронгуй болгох санал, санаачилгыг өрнүүлэх зорилгоор Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, мэргэжлийн холбоод, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчилал, хэмжил зүйн газартай хамтран “Стандарт ба шударга бизнесийн хөгжил” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

2009 онд Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн 1040 гомдол, мэдээллээс төрийн байгууллагуудын хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой 157 гомдол, мэдээллийг шийдвэрлэн, зөрчлийг арилгуулж, гомдолд дурдагдсан албан тушаалтанд хариуцлага тооцуулах ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн гомдол, мэдээлэл хүлээн авах 1969 утсаар ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр сурвалжлага бэлтгэн “Нийгмийн толь” сонины “1969 мэдээлж байна” буланд тогтмол нийтэлж, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг тоймлон олон нийтэд хүргэлээ.

Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллагуудад хандаж гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 118 төрийн байгууллагуудад мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод болгох, хүнд суртлыг арилгах талаар арга зүйн туслалцаа, зөвлөгөөг өгч ажилласны зэрэгцээ зөвлөмжийг сайн хэрэгжүүлж буй байгууллага дээр бусад байгууллагын төлөөллийг оролцуулан туршлага солилцуулах ажлыг зохион байгуулав.

Монгол Улсын Авлигын эсрэг хуулиар хүлээлгэсэн үүргийн дагуу бүх аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг дарга нар орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг боловсруулахдаа иргэд, олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэн, саналыг нь тусгах, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах талаар зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах зэргээр Монгол Улсын Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх ажил эрчимжиж байна.

Аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил төлөвлөгөөний дагуу идэвхжиж байна. Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр бүх аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөлд зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг нь хангах талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Баянхонгор, Булган, Өмнөговь, Хэнтий, Дундговь аймгууд үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бол Ховд, Сүхбаатар, Архангай аймгуудын ажлын зохион байгуулалт, үр дүн нь хангалтгүй байна.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлж, авлигатай тэмцэх арга барилд сургах ажлыг төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтнууд, иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулав. Тухайлбал, 2009 онд нийслэл дэх төрийн 107 байгууллагын 7440 албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтнууд болон 681 иргэнд авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөл, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, төрийн албаны ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах талаар сургалтуудыг зохион байгуулав.

Хүүхэд, залуучуудад шударга ёсны үзлийг төлөвшүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд шударга ёсны сэдвээр гар зураг, зохион бичлэгийн, их, дээд сургуулийн оюутнуудын дунд шилдэг илтгэлийн, сонин хэвлэлийн сэтгүүлч, сурвалжлагчдын дунд нийтлэл, сурвалжлагын уралдааныг тус тус зарлаж, 262 бүтээлийг хүлээн авч дүгнэсэн бөгөөд их, дээд сургуулийн оюутнуудад шударга

ёсны тухай лекцийг нэр хүнд бүхий хүмүүсээр уншуулж, авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажилд олон нийтийг татан оролцуулах ажлыг өрнүүлэв.

Шударга ёсыг бэхжүүлэх, шударга ёсны үлгэр дууриаллыг бий болгох зорилгоор “Шударга ёсны төлөө” шагналыг санаачлан шударга иргэн, төрийн болон төрийн бус байгуулага, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас тодорхой үзүүлэлтээр шалгаруулж, шагналыг гардуулах ёслолын арга хэмжээг НҮБ-аас батласан Олон улсын Авлигын эсрэг өдөр буюу 12 сарын 9-ний өдөр хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаагаа телевиз, радио, өдөр тутмын сонингоор сурталчлан, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийтлэл, мэдээг олон нийтэд хүргэж ажиллав. Тухайлбал, авлигын эсрэг сурталчилгааг 162 удаа телевизүүдээр нэвтрүүлж, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, төрийн болон төрийн бус байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаархи мэдээ, сурвалжлагыг сар бүр “Шинэ хуудас” мэдээллийн хуудаст нийтлэн түгээж, өдөр тутмын 4 сонинд мэдээллийн булан ажиллуулж, Монголын радиогоор “Авлигатай тэмцэх газраас ярьж байна” нэвтрүүлгийг 34 удаа бэлтгэн олон нийтэд хүргэв. Хөдөө орон нутгийн телевиз, радиод авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаархи телевизийн сурталчилгаа, радио сурталчилгаа бэлтгэн өгч, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүрэг, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг, авлигын хор хөнөөлийн талаар “Авлигыг Тал зогсоож чадна” сурталчилгааны 2 төрлийн танилцуулгыг 22500 ширхэг, “Авлигын эсрэг зарим хууль тогтоомж” товхимол 7000 ширхэг, “Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага”-ыг 3000 ширхэг, зурагт хуудас 6000 ширхэгийг тус тус хэвлүүлэн төрийн албан хаагч, иргэд, төрийн бус байгууллагын сүлжээнд тараах ажлыг зохион байгууллаа.

Улс орны хэмжээнд авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөлд хийсэн судалгаа, шинжилгээнд үндэслэн цаашид зохион байгуулах авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтооход онцгой анхаарч, Авлигатай тэмцэх газрын дарга, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 76/(01/69) дугаар хамтарсан тушаалаар батласан “Авлигын индекс тооцох аргачлал”-ын аргачлалын дагуу Монгол Улсын Авлигын индексийг тооцон гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлсэн /Дэлгэрэнгүй мэдээллийг <http://iaac.mn/index.php?cid=106>-ээс үзнэ үү/. УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолд заасны дагуу улс төр, хууль хяналтын

байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгааг мэргэшсэн шинжээч нарын хүрээнд хийж, эрдэмтэн, судлаачдаар хэлэлцүүлээ. Эдгээр судалгааны дүнг НҮБ-аас тунхагласан Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын Үндэсний тайлан илтгэлд оруулсан.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаа Монгол Улсад хийгдэж байгаагүй тул гадаад орны болон олон улсын байгууллагын ижил төстэй 6 аргачлалыг судлан, 5 удаа туршилт судалгаа хийж өөрийн орны онцлогт тохирсон аргачлал боловсруулсан.

Олон улсын Транспэрэнси Интернэшнл төрийн бус байгууллагын хүсэлтээр 60 улсыг хамарсан “Дэлхий нийтийн авлигын барометрийн судалгаа 2009”-г хамтран гүйцэтгэж, судалгааны үр дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн. Түүнчлэн Олон улсын Транспэрэнси Интернэшнл төрийн бус байгууллага, Галлап олон улсын судалгааны байгууллага, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн албаны судалгаа шинжилгээний нэгжтэй тогтмол мэдээлэл солилцон, хамтран ажиллаж байна.

Улирал тутмын “Шударга ёс” онол, арга зүйн цувралын анхны дугаарыг НҮБХХ-ийн санхүүжилтээр хэвлэн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, УИХ, Засгийн газрын харьяа яам, агентлаг, аймгуудад үнэгүй түгээх ажлыг зохион байгуулав.

Хоёр. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах чиглэлээр:

2009 онд улсын хэмжээнд албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан бүтэц, зохион байгуулалтад нь өөрчлөлт орсон Засгийн Газрын яам, агентлагуудын хэмжээнд мэдүүлэг гаргагчдын судалгаа гаргах, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын дэлгэрэнгүй судалгаа хийж, мэдүүлэг гаргагчдыг тогтоох, бүтэц, зохион байгуулалт, албан тушаалтны шилжилт хөдөлгөөн, томилгоонд хяналт тавьж ажиллан хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж хадгалах ажиллагааг холбогдох журмын дагуу хэрэгжүүлсэн.


Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг мэдээлэл, арга зүйн удирдлагаар ханган, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажилласны зэрэгцээ 71 байгууллага, тэдгээрийн салбар нэгжид 115 удаа сургалт явуулж, 4486 мэдүүлэг гаргагчдыг хамруулсан сургалт, сурталчилгааны ажлыг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэв.

Д/ д	ОН	Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх сургалт		Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх заавар, сурталчилгаа		
		Байгууллага	Сургалтанд хамрагсад	Гарын авлага	Хэвлэмэл хуудас	Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэлийн дэвтэр
1.	2007	56	5200	3000	1000	800
2.	2008	60	5600	6500	1000	0
3.	2009	71	4486	4000	3000	100
	Дүн	187	15286	13500	5000	900


“Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах арга зүйн сургалтын хөтөлбөр” боловсруулж, гарын авлага, товхимол 4000 ширхэгийг хэвлүүлэн төрийн захиргааны 120 байгууллага, тэдгээрийн салбар нэгжид хүргүүлэв. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон холбогдох баримт, бичгийг хадгалах, ашиглах журам”-ыг боловсруулан баталж, төрийн болон орон нутгийн нийт 120 байгууллагад хүргүүлсэн.

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэж, бүрдүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулсан нь хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайлан, мэдээний бодит байдалд хяналт тавихад үр дүнгээ өгч байна.


Улсын хэмжээнд хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэг бүхий 53016 мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 99,9 хувьтай бүртгэж хүлээн авлаа. Үүнээс 52915 нь буюу 99,8 хувь нь хуулийн хугацаанд, 64 нь буюу 0.12 хувь нь хугацаа хожимдуулж бүртгүүлсэн ба 37 нь буюу 0,06 хувь нь хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй буюу хугацаа хожимдуулж бүртгүүлсэн 16 албан тушаалтанд ажлаас халах, 12 албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу цалин бууруулах, 5 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.




Хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлбэл зохих албан тушаалтны тоо



Хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь бүртгүүлсэн албан тушаалтны тоо



Хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж бүртгүүлсэн албан тушаалтны тоо




Хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй албан тушаалтны тоо

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос бүх шатны сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ба 2008 оны Орон нутгийн Хурлын сонгуульд сонгогдогчийн 7680 хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч, хууль тогтоомжид нийцүүлэн хадгаламжийн 92 нэгж болгон холбогдох журмын дагуу хадгалав.

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг ил, тод нээлттэй байлгах, иргэд, олон нийтэд мэдээлэл авах боломжийг нь бүрдүүлэн Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу төрийн өндөр 242 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн тухай мэдээллийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дугаарт хэвлэн нийтлүүлж, Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд байрлууллаа.

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн төрийн албаны ангилал, зэрэглэлийн судалгаа, хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй буюу хугацаа хожимдуулсан албан тушаалтны судалгаа, хөрөнгө, орлогын мэдүүлгийн арга зүйн сургалтад хамрагдагсдын судалгаа, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл, урамшууллын шийдвэрлэлтийн судалгаа, хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайлан, мэдээний маягтын судалгаа, 2007, 2008 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчдын тоо нэмэгдсэн шалтгаан, нөхцөлийг өмнөх онтой харьцуулсан дэлгэрэнгүй судалгаа, албан тушаалын байдал нь өөрчлөгдөж хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлсэн Төрийн өндөр албан тушаалтны тухай зэрэг судалгааг тус тус хийж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэв. Одоо Монгол Улсад төрийн улс төрийн албан тушаалын -2113,

төрийн захиргааны албан тушаалын -13966, төрийн тусгай албан тушаалын -25772, төрийн бус байгууллагын - 27, бусад - 3454 хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч нар байна.



Хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд ирүүлээгүй 6 байгууллагын 21 эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, улирлын тайлан, мэдээгээ журамд заасан хугацаанд ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэн, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах чиглэлийн үйл ажиллагаа нь хангалтгүй байгаа 21 байгууллагад мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах давтан сургалтыг зохион байгуулав.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн зөрчлийн судалгааг 120 байгууллагын хэмжээнд хийж, үнэлэлт, дүгнэлт гаргав. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах үйл ажиллагаанд зөрчил гаргасан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 78 байгууллагын 48 эрх бүхий албан тушаалтанд анхааруулга, заавар, зөвлөмж өгч, ажил сайжруулах, зөрчлийг арилгуулах талаар 11 байгууллагад албан шаардлага хүргүүлж, 18 байгууллагад сургалт зохион байгуулж ажилласан.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын ажлын чиглэлээр:

2009 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын графикт төлөвлөгөөний дагуу 7 байгууллагад шалгалт хийсэн. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын чиглэлээр нийт 102 байгууллагын 1432 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг татан авч хянасан. Эдгээрээс 263 албан тушаалтны хөрөнгө,

орлогын мэдүүлгийг нарийвчлан шалгасан ба одоогийн байдлаар 239 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгаж дуусгаад 24 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах ажиллагаа үргэлжилж байна.

Хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо санаатай худал мэдүүлсэн 42 албан тушаалтныг илрүүлж, хуульд заасан хариуцлага тооцуулах тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж 6 албан тушаалтныг ажлаас халах, 6 албан тушаалтныг ажлаас нь түдгэлзүүлэх, 21 албан тушаалтны цалинг бууруулах, 7 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.


Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах журмыг шинэчлэн баталж, хяналт шалгалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд дээр бүртгэгдэж, хадгалагдаж байгаа хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны мэдүүлэг гаргагчдын цалингийн цэс дэх нэрсийн жагсаалттай болон Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайлан мэдээг ирүүлэх үүрэг бүхий 120 байгууллагын эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн салбар нэгжүүдээс ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлгийн 5 төрлийн тайлан, мэдээнүүд, урьдчилсан байдлаар авсан мэдүүлэг гаргагчдын судалгаа зэрэгтэй тулган хянах ажлыг нийт 114 байгууллагад зохион байгуулав.


”Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл өгөх журам”, “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон холбогдох баримт бичгийг хадгалах, ашиглах журам”, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах журам”-ыг тус тус баталж, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллав. Эдгээр журмуудын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны нийт 92 байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл, хадгалалт, тайлагнаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл, хадгалалтын зөрчилд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах, тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг арилгах арга хэмжээг авч ажиллав. “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам”-ын дагуу 2009 онд төрийн өндөр 3 албан тушаалтны болон төр, захиргааны байгууллагын 262 албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2009 оны бүрдүүлэлтээр хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулсан, бүртгүүлээгүй болон санаатай худал мэдүүлж зөрчил гаргасан 22 албан тушаалтанд Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 13


дугаар зүйлийн 13.5-д заасны дагуу ажлаас халах, 6 албан тушаалтанд ажлаас түдгэлзүүлэх, Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу 33 албан тушаалтанд цалин бууруулах, 33 албан тушаалтанд сануулах сахилгын арга хэмжээ тус тус авахуулж, 28 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг нөхөн гаргуулж, зөрчил дутагдлыг арилгуулсан.




Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасны дагуу ажлаас халсан албан тушаалтны тоо



Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасны дагуу ажлаас түдгэлзүүлсэн албан тушаалтны тоо



Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь хэсэгт заасны дагуу цалинг нь бууруулсан албан тушаалтны тоо



Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх хэсэгт заасны дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан албан тушаалтны тоо

Гурав. Монгол Улсын Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлууд:

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлд судалгаа хийж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх чиглэлээр эрдэмтэн судлаачид, холбогдох байгууллагын санал, зөвлөмжийг авч, хуулийн төсөл боловсруулсны зэрэгцээ хуулийн зарим зүйл заалтыг Улсын дээд шүүхээр тайлбарлуулах тухай саналаа боловсруулж хүргүүлсэн.

НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн заалтад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулан Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Дэлхийн банкны Засаглалыг дэмжих төсөлтэй хамтран боловсруулсан “Төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцид нийцүүлэх зорилгоор Монгол Улсын 9 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

“Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их хурлын тогтоолын төсөл боловсруулан УИХ-ын даргад 2009 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн.

УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, холбогдох 5 байгууллагын уялдаа, холбоог сайжруулах зорилгоор УИХ-ын Мянганы хөгжлийн зорилтууд, ядуурлын асуудал хариуцсан дэд хорооны даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулах саналыг тус дэд хорооны даргад хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчмыг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулж, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд үүний үр дүнд төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй ажиллаж байгааг нэгдсэн байдлаар, нэг аргаар үнэлэх боломж бүрдсэн.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллагууд “Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрэхэд саатуулах журам”-ыг тус бүртээ батлан мөрдүүлж, Хил хамгаалах ерөнхий газартай мэдээ, мэдээлэл солилцож ирсэн тогтолцоог өөрчлөн энэ журамд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлагатай болсныг харгалзан шинэчилсэн журмын төслийг Авлигатай тэмцэх газраас боловсруулж, 2009 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дарга нарын хамтарсан 133/499/535/07/44 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Гадаадын 11, дотоодын 10 судалгааны ажилд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулсан "Авлигын индексийн тооцох аргачлал"-ыг үндэсний хэмжээнд 6 удаа туршиж, аргачлалын төслийг үндэсний эрдэмтэн судлаачид, төрийн захиргааны төв байгууллагуудаар хэлэлцүүлэн зохих нэмэлт өөрчлөлт оруулан Авлигатай тэмцэх газрын дарга, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76(01/69) дугаар тушаалаар баталсан.

Дөрөв. Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ажлын чиглэлээр :


Авлигатай тэмцэх газар нь 2009 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 1040 гомдол, мэдээллийг хүлээн авсан. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 682 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг болон 8 дугаар зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газарт цагдаагийн байгууллагаас 106, яам, агентлаг болон түүний харьяа байгууллагуудаас 35, прокурорын байгууллагаас 23, Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас 14, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 13, мэргэжлийн хяналтын байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас тус бүр 12, аудитын байгууллагаас 11, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 4, шүүх, тагнуулын

байгууллага, Улсын Их Хурлын тамгын газраас тус бүр 1 буюу гэмт хэргийн шинжтэй нийт 233 мэдээлэл ирүүлсэн.

2009 онд нийт 707 гомдол, мэдээлэл шалгаснаас 72 гомдол, мэдээлэлд буюу 10.0 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 363 гомдол, мэдээлэлд буюу 51.0 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, 241 гомдол, мэдээллийг буюу 34.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 14 гомдол, мэдээллийг буюу 2.0 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгасан ба 29,774,573,857 (хорин есөн тэрбум долоон зуун далан дөрвөн сая таван зуун далан гурван мянга найман зуун тавин долоо) төгрөгийн хохирол бүхий хуульд заасан харьяаллын 5 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, 180 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулав.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийг төрлөөр нь авч үзвэл төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 59 буюу 18.0 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 11 буюу 3.0 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах гэмт хэрэг 9 буюу 3.0 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 3 буюу 1.0 хувь, хээл хахууль авах гэмт хэрэг 55 буюу 17.0 хувь, хээл хахууль өгөх гэмт хэрэг 42 буюу 13.0 хувь, хээл хахууль зуучлах гэмт хэрэг 6 буюу 2.0 хувь, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 8 буюу 3.0 хувь, бусад гэмт хэрэг 130 буюу 40.0 хувийг эзэлж байна.




Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн төрөл

Нийт мөрдөн шалгасан эрүүгийн 53 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 30.0 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 38 эрүүгийн хэргийг буюу 21.0 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар /эдгээрээс 9 эрүүгийн хэргийн 27 яллагдагчийн үйлдлийг 2009 оны өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хэрэгсэхгүй болгосон/, 39 эрүүгийн хэргийг буюу 21.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлэхээр тус тус шийдвэрлэж 23 эрүүгийн хэргийг буюу 12.0 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэсэн.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан 1,403,128,949 (нэг тэрбум дөрвөн зуун гурван сая нэг зуун хорин найман мянга есөн зуун дөчин ес) төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 4,689,860,386 (дөрвөн тэрбум зургаан зуун наян есөн сая найман зуун жаран мянга гурван зуун наян зургаа) төгрөгийн хөрөнгө битүүмжилж иргэний нэхэмжлэл хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Эрүүгийн хэрэгт нийт 437 хүнийг сэжигтэн, яллагдагчаар татаж шалгасан бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн албан тушаалтан 21 буюу 5.0 хувийг, төрийн захиргааны албан тушаалтан 78 буюу 18.0 хувийг, төрийн тусгай албан тушаалтан 72 буюу 16.0 хувийг, төрийн үйлчилгээний албан тушаалтан 60 буюу 14.0 хувийг, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 195 буюу 44.0 хувийг, гадаадын иргэн 11 буюу 3.0 хувийг тус тус эзэлж байна.



Эрүүгийн хэрэгт татаж шалгасан сэжигтэн, яллагдагчийн албан тушаалын ангилал

Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргүүдээс 2009 онд 36 шүүгдэгчид холбогдох 16 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 12 хэргийн 15 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон ял шийтгэж, 6 хэргийн 17 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ял шийтгэлээс чөлөөлж шийдвэрлэсэн байна.

Авлигатай тэмцэх газар авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэн ажилласан. Үүний дотор Хонг Конгийн Авлигын гэмт хэргийг мөрдөх товчоо, АНУ-ын Холбооны мөрдөх товчоо зэрэг байгууллагатай зарим эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах талаар хамтран ажилласан ба Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын авлигатай тэмцэх албатай ажлын харилцаа холбоо тогтоон тус байгууллагад бүртгэгдсэн ажлын шилдэг туршлагыг судлан үйл ажиллагаандаа ашиглах ажлыг зохион байгуулж байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ:
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХИ
МЭДЭЭЛЭЛ**

Авлигын төсөөллийн индекс гаргаж олон нийтэд түгээдэг “Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас гаргасан авлигын төсөөллийн индексээр Монгол Улсын 2009 оны индекс 2,7 байгаа ба Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн өөрчлөлтийг тус байгууллагаас дараах байдлаар тайлбарлажээ.

Монгол Улсын хувьд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны судалгаа болон олон улсын судалгааны байгууллагуудын нийт 7 эх үүсвэрийг ашигласан бөгөөд Economic management буюу улс орны эдийн засгийн менежмент сул байгаа, засгийн газрын үйл ажиллагаа ил тод бус, хариуцлага хүлээлгэх механизм үйлчлэхгүй байгаа зэрэг үзүүлэлтүүд авлигын төсөөллийн индекс буурахад нөлөөлсөн. Манай улсын талаар дэлхий дахинд мэдээлэгдсэн зарим үйл явдлууд ийм дүгнэлтэнд хүргэсэн бөгөөд заримыг нь дурдъя:

1. Засгийн газар, төрийн албаны үйл ажиллагаа ил тод бус байгаа (Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлах ажил 10 жил үргэлжилж байна);
2. Оюу толгойн ордыг ашиглах гэрээг олон жил боловсруулсан байдал (Ашигт малтмалын тухай хуулийг төгс боловсруулж чадаагүй, засгийн газрын гэрээ боловсруулах чадавхи сул, хугацаа алдах, оролцогч, сонирхогч талуудад авлига үйлдэх нөхцөл бүрдэх аюул учрах г.м.);
3. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын сонгуульд санал худалдаж авах явдал газар авснаас гадна хууль бус үйлдэл үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон ч хууль хэрэгжихгүй байх (“election fraud” гэж нэрлэх сонгуулийн будлиан, залилан үйлдсэнээр иргэдийн эдлэх үндсэн эрх болох сонгох, сонгогдох эрх зөрчигдөх г.м.);
4. Авлига буюу албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өршөөлд хамруулах хууль батлан хэрэгжүүлснээр авлигатай хийх тэмцлийн үр нөлөө буурах нөхцөл бүрдсэн гэж дүгнэсэн.

	2006	2007	2008	2009
Монгол	2.8	3.0	3.0	2.7


Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс, оноор

Тухайн нэг улс орны авлигын төсөөллийн индекс өөрчлөгдөхөд зөвхөн авлигатай тэмцэх байгууллагынх нь үйл ажиллагаанд дүгнэлт хийдэггүй, харин тухайн орны улс төрийн нөхцөл байдал, улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, улс орны эдийн засгийн байдал, ядуурал, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй,

хариуцлагатай байдал, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр гарсан ололт, алдаа, дутагдал гэх зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан үздэг байна. Мөн энэ индексийн үзүүлэлт нь хүмүүсийн төсөөлөлд тулгуурладаг учраас тухайн жилд илэрсэн авлигын томоохон хэргүүд, олон улсын түвшинд болон улс орны дотоодод гарсан улс төр, улс төрчидтэй холбоотой дуулиан, шуугиан нь авлигын төсөөллийн индекс өөрчлөгдөхөд хүргэдэг.

Авлигын төсөөллийн индексийн судалгаанд хамрагдсан улсын 35.8 хувьд нь авлигын төсөөллийн индексийн утга өссөн бол 21.8 хувьд нь авлигын төсөөллийн индексийн утга өөрчлөгдөөгүй, 42.5 хувьд нь буюу дэлхийн улс орнуудын бараг тал хувьд нь авлигын төсөөллийн индексийн утга буурсан байна (Зураг 1). Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт улс орнуудад буурах болсон нь санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр бизнес эрхлэгчид хямралыг хохирол багатай даван туулахын тулд төрийн албан хаагчид, төр, засгийн үйл ажиллагаанд нөлөөлөх болсонтой шууд холбоотой гэж үздэг байна.


Зураг 1. Авлигын төсөөллийн индексийн өөрчлөлт /дэлхийн улс орнуудаар/



Монгол Улс дахь авлигын төлөв байдлын судалгаа

Авлигын талаар тогтмол, тодорхой хугацааны давтамжтайгаар хийгдэж ирсэн судалгаа бол АНУ-ын төрийн бус байгууллага Азийн сангаас 2006 оны 3 дугаар сараас зохион байгуулж ирсэн “Авлигын түвшин тогтоох судалгаа” юм. Энэхүү судалгааны үр дүнгээр авлигын талаархи иргэдийн төсөөлөл цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг үнэлж дүгнэх боломжтой. Уг судалгааны дүнгээс харахад 2006-2007 онд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 28.0-22.0 хувь нь авлига тэдний санааг зовоож буй гол асуудлуудын нэг гэж хариулж байсан бол 2009 онд 11,4 хувь болсон нь сүүлийн 3 жилд улс орны хэмжээнд зохион байгуулагдсан авлигаас

урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын үр дүн гэж үзэж болно. Азийн сангийн судалгаанаас үзэхэд Монгол Улсад авлига түгээмэл гэж тооцдог иргэдийн эзлэх хувийн жин аажмаар буурч байна.



Авлига хамгийн их сэтгэл зовоосон асуудал гэж үзэж буй иргэдийн эзлэх хувийн жин


Тодорхой улс орны хууль эрх зүйн орчин, нийгэм, улс төрийн байгуулал, түүх, соёл, уламжлал зэргийн ялгаатай байдлаас шалтгаалан авлига нь олон хэлбэртэй байдаг хэдий ч авлигын зонхилох хэлбэр нь хээл хахууль юм. Транспэрэнси Интернэшнл олон улсын төрийн бус байгууллагын захиалгаар Галлап олон улсын судалгааны байгууллагаас зохион байгуулдаг Дэлхий нийтийн авлигын хэмжүүр судалгааны 2009 оны дүн дэлхий нийтийн хэмжээнд хээл хахууль өгөх явдал их байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдагсдын 13.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан бөгөөд үүний эдийн засгийн үр дагавар нь эмзэг бүлгийн буюу ядуу иргэдэд илүү хүчтэй нөлөөлдөг гэж дүгнэжээ.

Монгол Улсын хувьд судалгаанд хамрагдагсдын 32.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэг байдлаар хээл хахууль өгсөн гэж хариулсан нь дэлхий нийтийн дунджаас 19.0 хувиар өндөр байна.

Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигын индексийг тооцох зорилгоор 2009 онд зохион байгуулсан Олон нийтийн төсөөллийн судалгааны дүнгээс харахад Монгол Улсын нийт 677.8 мянган өрхийн 13.3

хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад ямар нэг байдлаар хээл хахууль өгсөн, нэг өрх дунджаар 240.8 мянган төгрөгийг хээл хахуульд өгсөн гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан өрхийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн хэмжээг тооцож үзэхэд нийт 21.7 тэрбум төгрөг болж байна. Энэ нь авлигын цар хүрээний зөвхөн нэг л талыг харуулах үзүүлэлт юм.

“Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн” гэж хариулсан хүмүүсийн 59.0 хувь буюу талаас илүү хувь нь тухайн тохиолдолд хээл хахуульгүйгээр асуудлаа шийдвэрлүүлэх боломжгүй гэж урьдаас мэдэж байсан, албан тушаалтан шаардаагүй боловч би хээл хахууль өгсөн нь найдвартай гэж хээл хахууль өгөх болсон шалтгаанаа тайлбарлажээ. Энэ байдлаас төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх болсон нэг хүчин зүйл нь иргэд, олон нийтийн зүгээс гаргаж буй санаачлага байж болохоор байна. Иргэд, олон нийт төрийн үйлчилгээний талаар мэдлэг, мэдээлэл муутай байдаг, тухайн асуудлыг дүрэм, журмын нь дагуу шийдвэрлүүлэх шат дарааллыг сайн мэддэггүйгээс хээл хахууль өгч асуудлаа шийдвэрлүүлдэг нь харагдлаа. Цаг хугацааны давтамжийн хувьд манай улсын иргэдэд хээл хахуультай холбоотой асуудал дунджаар 212 хоног буюу 7 сар тутамд тулгардаг байна.



Өнгөрсөн 3 сарын хугацаанд та эсхүл танай өрхөөс аль нэг гишүүн ямар нэг хэлбэрээр хахууль өгсөн үү? гэсэн асуултад “Өгсөн” гэсэн хариултын эзлэх хувийн жин

Авлигын талаархи бизнес эрхлэгчдийн төсөөллийн 2009 оны судалгааны дүн нь төр, бизнес хоёрын зохисгүй холбоо хамаарал буюу хувийн хэвшлийн бизнес нь төрийн албан хаагч, улс төрчдийг дэмжиж ашиг хонжоо олдог гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадтай хамтарсан аж ахуйн нэгжүүд төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагад хандив, дэмжлэг үзүүлэх хандлага илүү их байна. Үүний цаана хээл хахууль, авлигын асуудал нуугдаж байгаа нь тодорхой. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 3.9 хувь нь улс төрийн аль нэг намд тусламж, дэмжлэг үзүүлсэн гэж хариулсан нь сонирхол татахуйц дүн мөн. Улс төрийн нам, улс төрчдөд төрийн өмчийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр тусламж, дэмжлэг үзүүлж, тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хэвээр үлдэх сонирхол байдаг нь эндээс харагдлаа. Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцийг оновчтой, дээрх нөхцөл байдлаас ангид байх нөхцөлийг хангаж бүрдүүлэх нь зүйтэй юм.

Судалгаанд хамрагдсан гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн 3 нэгж тутмын нэг нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан ба экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг аж ахуйн 4 нэгж тутмын нэг нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд Монгол Улсад үйл ажиллагаа явуулахдаа төрийн албан хаагч, улс төрчдөд хээл хахууль өгөх нь илүү түгээмэл байгаад дүгнэлт хийж, онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төрийн албаны үйл ажиллагаан дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааны талаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын дунд явуулсан төсөөллийн судалгааны дүнгээс үзэхэд үйл ажиллагааны хариуцлагагүй байдал, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг байдал, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах явдал, хүнд суртал, албан хаагчдын мэдлэг, чадвар нь хангалтгүй, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр дүнгүй, шагнал урамшууллын болон томилгооны талаарх удирдлагын шийдвэр бодитой бус, улс төрийн нөлөөллөөс хамааралтай байгаа нь тодорхой салбар дахь авлигын тархцын түвшинд шууд хүчтэй нөлөөлж байна

Авлига дээд түвшинд буюу улс төр, хууль хяналтын хүрээнд илүү түгээмэл байна гэж судалгаанд хамрагдсан иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгч, шинжээчид үзжээ. Монгол Улс дахь авлигын тархцын талаар судалгаанд хамрагдагсдын 66.8 хувь нь шүүхийг, 58.4 хувь нь улс төрийн намуудыг, 55.0 хувь нь Улсын Их Хурлыг, 49.8 хувь нь төрийн албан хаагчдыг авлигад ихээхэн автсан үзсэн байна. АНУ-ын Азийн

сангийн 2009 оны 9 дүгээр сарын судалгаагаар иргэд хамгийн их авлигад өртсөн салбараар газрын алба, шүүх, цагдаа, прокурор, уул уурхайн салбарыг нэрлэжээ.

Авлигын төлөв байдлыг үндэсний түвшинд илтгэн харуулах нэгдсэн үзүүлэлт болох Авлигын индексийг Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д заасны дагуу 2009 онд үндэсний түвшинд болон салбараар 0-1 үзүүлэлтээр тооцон гаргаж олон нийтэд мэдээлсэн. / Индекс нь 1 гэсэн үзүүлэлтэд ойр байх тусам авлигын эрсдэл бага байгааг харуулна /

Монгол Улсын 2009 оны авлигын индекс 0.64 байна. Индексийн гол зорилго нь авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааны цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийг харуулах явдал бөгөөд цаашид авлигын индексийг хоёр жил тутам тооцож, индексийн өөрчлөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж байх болно.

Авлигын индекс /салбараар/

Салбарын ангилал	Авлигын индекс
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын	0.71
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын	0.69
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын	0.65
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын	0.64
Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын	0.64
Сангийн сайдын эрхлэх асуудлын	0.63
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын	0.63
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын	0.63
Шадар сайдын эрхлэх асуудлын	0.63
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын	0.61
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын	0.61
Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын	0.47

Аймаг, нийслэл	Авлигын индекс
Төв	0.71
Говьсүмбэр	0.67
Дундговь	0.66
Дорноговь	0.66
Булган	0.66
Завхан	0.64
Сэлэнгэ	0.64
Улаанбаатар	0.60
Өвөрхангай	0.60
Дархан-Уул	0.60
Дорнод	0.59
Говь-Алтай	0.59
Сүхбаатар	0.58
Баянхонгор	0.58
Хэнтий	0.56
Хөвсгөл	0.55
Өмнөговь	0.55
Баян-Өлгий	0.54
Увс	0.54
Орхон	0.49
Ховд	0.49
Архангай	0.47

Авлигын индексийг тооцохтой холбоотойгоор цуглуулсан тоо, мэдээлэлд үндэслэн авлигын эдийн засгийн үр дагаврыг нэгтгэн дүгнэхэд:

1. Монгол Улсын нийт 677.8 мянган өрхийн 13.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад ямар нэг байдлаар хээл хахууль өгсөн, нэг өрх дунджаар 240.8 мянган төгрөгийг хээл хахуульд өгсөн гэсэн үзүүлэлтийг ашиглан өрхийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн хэмжээг тооцоолоход 21.7 тэрбум төгрөг болж байна. Энэ хэмжээний хөрөнгөөр Монгол Улсын дундаж амьдралтай 4921 өрхийн бүтэн жилийн хэрэгцээг хангахаар байна.
2. Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үнийн дүнгийн 10.1 хувь нь авлига, хээл хахуульд зарцуулагддаг байна.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээний үнийн дүнгийн 10.5 хувь нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагддаг гэж шинжээчид дүгнэжээ.
4. Шинжээчдийн үзэж байгаагаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд дунджаар татварт төлөх ёстой үнийн дүнгийн 11.5 хувийг авлига, хээл хахууль хэлбэрээр зарцуулдаг байна.

Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээлэл, иргэд, олон нийтийг татан оролцуулж зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР